

МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/339

Номгон

Г Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тухай Г


Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 15.4, 16 дугаар зүйлийн 16.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1, 5.3 дугаар зүйлийн 1, 5.5 дугаар зүйлийн 10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудлаар дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн дүгнэлтийн дагуу Баянхонгор сумын “Дөөд эрдэнэ” ХХК-ний Энх баян, “Хүчит тамсаг” ХХК-ий Тамсаг булаг, “Энх сондор од” ХХК-ий Энх сондор од, “Буянт элти транс” ХХК-ий Шаргалжуут-1, “Аядуу богд” ХХК-ий Өнө-Эрдэнэ, Баянговь сумын “Түвшин нэмэх оргил” ХХК-ий Оргил, Шинэжинст сумын “Тамсаг Бога” ХХК-ий Тамсаг, Баян-Овоо сумын “Асгамбахайрхан өгөөж” ХХК-ий Баруун булаг хүнсний дэлгүүрүүдийн тусгай зөвшөөрлийн хугацааг 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс 2029 оны 06 дугаар сарын 06-ны өдрийг хүртэл 5 жилийн хугацаагаар сунгасугай.

2.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан журам, шийдвэр, цагийн хуваарийг чанд мөрдөж, иргэдэд стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүн худалдаалахыг аж ахуйн нэгжийн захирал Ц.Эрдэнэбат, Б.Энх-Амгалан, С.Баярмагнай, Д.Ганбат, Я.Амарсанаа, Б.Нансалмаа, Б.Түвшинтөр С.Ариунаа нарт, холбогдох хууль, дүрэм, журмыг хэрэгжүүлэн ажиллаж байгаад хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Б.Мөнхбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль,эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

24010947